

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга	
1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг хариуцлага.....	4
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	5
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.5 Дотоод хяналт.....	6
2.6 Үйлдвэрлэл, борлуулалт, зорилтот түвшин.....	6
2.7 Шилэн дансны мэдээлэл.....	7
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	7
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	7
2.9.1 Балансаас балансад шилжүүлсэн үндсэн хөрөнгийн бүртгэл	7
2.10 Анхаарал татхуйц бусад чухал асуудал.....	8
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	8
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	8
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАР ИВЭЭЛ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАЯР ТАНАА

2018.03.14 № 06/671
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0314SAG9.Docx

070932

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Үүрэг, хариуцлага

Газар ивээл ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0314SAG9.Docx

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Газар ивээл ТӨААТҮГ-ын захирал Г.Энхбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага нь санхүүгийн тайлангаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 23-наас 2018 оны 3 дугаар сарын 14-ний хооронд хийхээр



төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар Юнистар Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Тэрбиш ахлагчтай баг гүйцэтгэв.

Газар ивээл ТӨААТҮГ нь 2017 оны санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд багтаан 2018 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 03/08 дугаартай албан бичгээр Юнистар Аудит ХХК-д ирүүлсэн.

2.3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Газар ивээл ТӨААТҮГ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуульд заасан ялтныг хөдөлмөрт татан оролцуулах, ажлын байраар хангах зорилгоор гутал, арьсан эдлэлийн үйлдвэрлэл явуулж байна. Гутлын үйлдвэрт хоригдлуудыг 2-3 дамжлагад ажиллуулж, ур чадвар олгон, арьсан эдлэл хийх арга барилд сургаж цалин хөлс олгон ажиллаж байна.

Газар ивээл ТӨААТҮГ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг худалдан авах тухай, Компанийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай болон холбогдох бусад хуулиуд, СТОУС, НББОУС тэдгээрт нийцүүлэн гаргасан Сангийн сайдын тушаалаар батлагдсан заавар, журмыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй байна.

2.4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд АОУС, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс тус байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, 8 дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 26 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг UNICUS програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.


Газар ивээл ТӨААТҮГ нь ШШГЕГ-ын харъяанд ажилладаг ба үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөлтийг ШШГЕГ баталдаг. Захирал, нягтлан бодогч, нярав, үйлдвэрлэлийн технологич гэсэн 4 орон тоотой. Газар ивээл ТӨААТҮГ-ын захирлыг ШШШЕГ-ын даргын тушаалаар томилж чөлөөлдөг. Байгууллагын удирдлага нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дотоод хяналт шинжилгээ үнэлгээ хийх журам зэрэг эрх зүйн актын хүрээнд дотоод хяналтыг зохион байгуулж, ажиллаж байна.

Газар ивээл ТӨААТҮГ-ын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байлаа.

2.6. Үйлдвэрлэл, борлуулалт, зорилтот түвшин

Газар ивээл ТӨААТҮГ нь өөрийн орлогоор санхүүждэг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар боловч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дугаарт "Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, эд хөрөнгийн талаархи бүрэн эрхийг уг асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу тус газрын 2017 оны үйлдвэрлэл борлуулалтын төлөвлөгөөг ШШГЕГ-ын даргын 2017 оны А/07 тоот тушаалаар баталсан байна. Уг төлөвлөгөөгөөр тус газар 231.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 306.5 сая төгрөгийн борлуулалт хийх зорилт тавьсан бол гүйцэтгэлээр 302.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 394.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Үйлдвэрлэлийн төлөвлөгөө 130.4 хувиар, борлуулалтын төлөвлөгөө 128.6 хувиар тус тус биелсэн байна.

ШШГЕГ-аас 225.0 сая төгрөгийн захиалга орж ирснийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн. Энэ захиалгатай холбоотойгоор бараа материалын үлдэгдэл 136.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 327 дугаар тогтоолоор тус газрын өмчлөлд байсан 107.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй үйлдвэрийн барилгыг 407-р хорих ангийн балансад шилжүүлсэн. Балансаас балансад шилжүүлсэн дээрхи барилгад холбогдох 68.6 сая төгрөгийн



дахин үнэлгээний нэмэгдлийг хаасан. Мөн батлагдсан төлөвлөгөөний дагуу дээд байгууллага ШШГЕГ-т 25.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн. Тайлант онд үйл ажиллагаагаар 45.3 сая төгрөгийн ашигтай ажиллаж 4.5 сая төгрөгийн татвар төлөхөөр тайлагнасан.

2.7. Шилэн дансны мэдээлэл

Газар ивээл ТӨААТҮГ нь Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зарчмын дагуу нийт 616.4 сая төгрөгийн орлого, 442.1 сая төгрөгийн зарлагын дүн бүхий 41 удаагийн гүйлгээ, худалдан авах ажиллагааны болон жилийн төлөвлөгөө, тендерийн мэдээлэл, санхүүгийн тайлан, гэрээ хэлцэл, орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээ зэргийг хуулийн дагуу сар, улирлаар оруулсан байна.

2.8. Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 дансанд эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын болон нарийвчилсан горим, сорил 26-г гүйцэтгэв.

2.9. Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг нотлохын тулд, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, дансны өглөг, эзэмшигчдийн өмч, борлуулалтын орлого, өртөг зардал зэрэг дансад ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгахад /ТАБ-СТА-В-3/ дараах зөрчилтэй асуудлууд илрэв. Үүнд:

2.9.1. Балансаас балансад шилжүүлсэн үндсэн хөрөнгийн бүртгэл

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 327 тоот тогтоолоор тус газрын балансаас 407-р хорих ангийн балансад шилжүүлсэн 107.1 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилгыг данснаас хасахдаа орлого үр дүнгийн тайланд татвар ногдох орлогоос хасагдах зардлаар бүртгэсэн.

Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.-д “Дараахь зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцсоны үндсэн дээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.” гэснийг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн болон татварын тайланд аудитын явцад зохих залруулга хийсэн.

2.10. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй.

2.12. Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 107.1 сая төгрөгийн тайлагналын алдаа илэрсэн ба уг алдааг аудитын явцад залруулсан болно.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд 1 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь байна.

2.14. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувиар тооцож 3.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. /ТАБ-СТА-В-1/

2.15. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Зөрчилгүй санал дүгнэлт

Газар ивээл ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

ЮНИСТАР АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

ХЯНАСАН:
ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭРБИШ

Т.ЭНХТУЯА

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН Ү ЭЭ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	21,966,920.94	97,353,116.52
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		1,963,669.20
1.1.4	Бусад авлага		4,197,500.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	6,418,513.21	142,819,479.40
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө(борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	28,385,434.15	246,333,765.12
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	189,492,919.82	84,249,494.80
1.2.2	Биет бус хөрөнгө	3,633,397.39	2,745,858.91
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	193,126,317.21	86,995,353.71
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	221,511,751.36	333,329,118.83
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,124,541.75	20,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		
2.1.1.4	НДШ-ийн өглөг		

9,525,491.74 4,527,525.73

01

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		225,000,000.00
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө(борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	12,650,033.49	229,547,525.73
2.1.2			
2.1.2.1	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Урт хугацаат зээл		
2.1.2.3	Нөөц/өр төлбөр/		
2.1.2.4	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.5	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6			
2.2	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.3	Өр төлбөрийн нийт дүн	12,650,033.49	229,547,525.73
2.3.1	Үгүй өгөөдөг өр		
2.3.2	Өмч : - төрийн	209,570,029.00	209,570,029.00
2.3.3	-хувийн		
2.3.4	-хувьцаат		
2.3.5	Халаасны хувьцаа		
2.3.6	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.7	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	68,637,200.00	
2.3.8	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.9	Эздийн өмчийн бусад хэсэг	1,934,810.33	1,934,810.33
2.3.10	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(71,280,321.46)	(107,723,246.23)
2.3.11	Тайлангийн үеийн		(86,289,024.77)
2.3.12	Өмнөх үеийн	(71,280,321.46)	(21,434,221.46)
2.4	Эзэмшигчдийн өмчийн дүн	208,861,717.87	103,781,593.10
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	221,511,751.36	333,329,118.83

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31

Мөрийн дугаар		ᠠᠶᠢᠨᠣᠳ	ᠤᠯᠡᠭᠦᠨᠠᠶᠢᠨᠣᠳ
			/Төгрөгөөр/
1.1.20	Борлуулалтын орлого (цэвэр)	213,922,090.96	394,354,181.80
1.2	Борлуулалтын өртөг	158,524,190.85	298,459,933.93
1.3	ᠠᠶᠢᠨᠣᠳ ᠠᠶᠢᠨᠣᠳ (ᠠᠶᠢᠨᠣᠳ)	55,397,900.11	95,894,247.87
1.4	Түрээсийн орлого		
1.4.1	Хүүний орлого	857,478.96	3,583,766.15
1.4.2	Ногдол ашгийн орлого		
1.4.3	Эрхийн шимтгэлийн орлого		
1.4.4	Бусад орлого		
1.4.5	Борлуулалт, маркетингийн зардал		
1.4.6	Ерөнхий ба удирдлагын зардал	48,043,506.50	54,152,952.76
1.4.7	Санхүүгийн зардал		
1.4.8	Бусад зардал		
1.4.9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
1.4.10	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(8,025,363.08)	(107,124,704.90)
1.4.11	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
1.4.12	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн үүссэн олз (гарз)		
1.4.13	Бусад ашиг (алдагдал)	94,805,940.76	(19,956,875.00)
1.4.14	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	94,992,450.25	(81,756,518.64)
1.4.15	Орлогын татварын зардал	821,196.26	4,532,506.13
1.4.16	Татварын дараах ашиг алдагдал	94,171,253.99	(86,289,024.77)
1.4.20	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
1.5	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	94,171,253.99	(86,289,024.77)
2	Бусад дэлгэрэнгүй орлого		
2.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
2.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
2.3	Бусад олз (гарз)		
6	Орлогын нийт дүн	94,171,253.99	(86,289,024.77)
6.1	ᠠᠶᠢᠨᠣᠳ ᠠᠶᠢᠨᠣᠳ (ᠠᠶᠢᠨᠣᠳ)		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31

Мөрийн дугаар	ᠰᠡᠭᠡᠨ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ	/төгрөгөөр/	
		ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ	ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ
1	ᠰᠡᠭᠡᠨ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	237,786,440.00	659,059,600.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	234,561,840.00	658,809,600.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөө хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас санхүүжилтийн орлого		
	ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ	3,224,600.00	250,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	199,868,557.01	542,781,490.57
	Ажиллагчдад төлсөн	79,337,584.78	95,101,710.56
	ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ	1,099,575.92	823,108.94
	Бараа материал худалдан авахад төлсөн	89,597,785.00	388,473,543.72
	ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ	5,776,627.00	
	ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ	700,000.00	3,639,000.00
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	13,057,089.31	37,582,077.35
	ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ		
	Бусад мөнгөн зарлага	10,299,895.00	17,162,050.00
1.3	ᠰᠡᠭᠡᠨ ᠶ᠋ᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ	37,917,882.99	116,278,109.43
2	ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ ᠠᠵᠢ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	857,478.96	4,108,086.15
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацааны хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		524,320.00
	Хүлээн авсан хүүний орлого	857,478.96	3,583,766.15
	Хүлээн авсан ногдол ашиг		

2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		20,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		19,500,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		500,000.00
2.3	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ (-)	857,478.96	(15,891,913.85)
3	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ (+)		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
	Бусад мөнгөн орлого		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,000,000.00	25,000,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
	Бусад	20,000,000.00	25,000,000.00
3.3	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ (-)	(20,000,000.00)	(25,000,000.00)
4	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ	18,775,361.95	75,386,195.58
5	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ	3,191,558.99	21,966,920.94
6	ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠵᠢᠷᠯᠠᠭᠢᠨ ᠳᠦᠨ	21,966,920.94	97,353,116.52

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2017 оны 12-р сарын 31

/Төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Гадаад валютын Хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	209,570,029.00			68,637,200.00		1,934,810.33	- 165,451,575.45	114,690,463.88
2	Нягтлан бодох бүртгэлийн								-
3	Залруулсан үлдэгдэл								-
4	Тайлант үеийн цэвэр ашиг							94,171,253.99	94,171,253.99
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн								-
9	2016 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	209,570,029.00	-	-	68,637,200.00	-	1,934,810.33	(71,280,321.46)	208,861,717.87
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(68,637,200.00)			49,846,100.00	(18,791,100.00)
11	Залруулсан үлдэгдэл								-
12	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал							(86,289,024.77)	(86,289,024.77)
13	Бусад дэлгэрэнгүй орлого								-
14	Өмчид гарсан өөрчлөлт								-
15	Зарласан ногдол ашиг								-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	2017 оны 12 сарын 31 өдөр	209,570,029.00	-	-	-	-	1,934,810.33	(107,723,246.23)	103,781,593.10

Бэлтгэсэн: Аудитор

Б.Тэрбиш

2018 оны 03-р сарын 09-ний өдөр

